



УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

I-IV/2026

Тархаасан: 2026 оны 05 дугаар сарын 14

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар өсжээ.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2026 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 10.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.2 (13.8%) их наяд

төгрөгөөр, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 8.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 459.7 (5.4%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

ХҮСНЭГТ 1. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТЭНЦЭЛ

Үзүүлэлт	Жил			Эхний 4 сар			2026* I-IV 2025 I-IV	
	2023	2024	2025*	2024 I-IV	2025 I-IV	2026* I-IV	зөрүү	хувь
	тэрбум төгрөг							
Нийт орлого	24 387.1	31 456.6	32 645.9	10 271.3	8 967.6	10 206.4	1 238.8	13.8
Тэнцвэржүүлсэн орлого	23 294.9	29 670.8	30 057.7	9 919.9	8 487.8	8 947.4	459.7	5.4
Зарлага, цэвэр зээл	22 509.0	30 591.1	31 289.2	7 786.2	8 545.7	10 372.0	1 826.3	21.4
Тэнцэл	785.9	- 920.2	- 1 231.5	2 133.6	- 57.9	- 1 424.6	-1 366.6	24.6**


** Дахин их

*Урьдчилсан гүйцэтгэл

Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2026 оны эхний 4 сард 10.4 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарчээ.


ЗУРАГ 1. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТЭНЦЭЛ

Нийт тэнцвэржүүлсэн орлого, их наяд төгрөг




*Урьдчилсан гүйцэтгэл

Нийт зарлага, их наяд төгрөг



Тэнцэл, (+,-), тэрбум төгрөг



Татварын нийт орлого 2026 оны эхний 4 сард 8.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 344.5 (4.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд нийгмийн даатгалын орлого 290.1 (17.6%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 105.8 (5.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

Харин орлогын албан татварын орлого 148.7 (5.7%) тэрбум төгрөгөөр, онцгой албан татварын орлого 108.3 (28.6%) тэрбум төгрөгөөр төгрөгөөр буурчээ.

ХҮСНЭГТ 2. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО

Үзүүлэлт	Жил			Эхний 4 сар			2026* I-IV 2025 I-IV	
	2023	2024	2025*	2024 I-IV	2025 I-IV	2026*I-IV	зөрүү	хувь
	тэрбум төгрөг							
Тэнцвэржүүлсэн орлого	23 294.9	29 670.8	30 057.7	9 919.9	8 487.8	8 947.4	459.7	5.4
Татварын орлого	21 484.2	27 417.4	27 085.9	9 377.9	7 954.1	8 298.6	344.5	4.3
Орлогын албан татвар	5 702.6	8 970.6	8 539.1	3 555.8	2 629.0	2 480.3	- 148.7	- 5.7
Нийгмийн даатгалын орлого	3 950.8	4 731.8	5 624.1	1 286.4	1 649.3	1 939.4	290.1	17.6
НӨАТ	4 777.0	5 866.8	6 224.3	1 768.8	1 838.8	1 944.6	105.8	5.8
Онцгой албан татвар	790.1	1 107.4	955.1	364.4	379.2	270.9	- 108.3	- 28.6
Гадаад үйл ажиллагааны татвар	1 465.3	1 792.3	1 849.4	510.1	556.4	606.5	50.1	9.0
Бусад татвар	4 798.3	4 948.5	3 893.8	1 892.4	901.4	1 056.9	155.5	17.3
Татварын бус орлого	1 810.7	2 253.5	2 971.8	542.0	533.7	648.8	115.2	21.6

*Урьдчилсан гүйцэтгэл


2026 оны эхний 4 сард татварын нийт орлогын 29.9 хувийг орлогын албан татвар, 23.4 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 23.4 хувийг нийгмийн даатгалын орлого, 7.3 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 3.3 хувийг онцгой албан татварын орлого, 12.7 хувийг бусад

төрлийн татвар, төлбөр, хураамжийн орлого тус тус бүрдүүлж байна.

Орлогын албан татварын 60.8 хувийг ААНОАТ, 39.2 хувь (буцаан олголтыг оруулсан дүнгээр)-ийг ХХОАТ-ын орлого бүрдүүлж байна.

ЗУРАГ 2.

УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар, 2026 оны эхний 4 сард



*ХХОАТ-ын буцаан олголт орсон дүн

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2026 оны эхний 4 сард 10.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.8 (21.4%) их наяд төгрөгөөр өсжээ. Зарлага өсөхөд урсгал шилжүүлэг өмнөх оны мөн үеэс 328.5 (8.3%) тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 877.7 (2.2 дахин) тэрбум төгрөгөөр, бараа үйлчилгээний зардал 493.5

(15.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

2026 оны эхний 4 сард нийт зардалд урсгал шилжүүлэг 41.4 хувь, бараа үйлчилгээний зардал 34.7 хувь, хөрөнгийн зардал 15.4 хувь, хүүгийн зардал 4.8 хувь, татаас 3.7 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3.**УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ, голлох зардлуудаар, жил бүрийн эхний 4 сард, дүнд эзлэх хувиар**

*Урьдчилсан гүйцэтгэл

Хөрөнгийн зардал 2026 оны эхний 4 сард 1.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 877.7 (2.2 дахин) тэрбум төгрөгөөр өсжээ. Үүнд барилга байгууламжийн зардал 730.7 (2.4 дахин) тэрбум

төгрөгөөр, их засварын зардал 36.9 (2.8 дахин) тэрбум төгрөг, бусад хөрөнгийн зардал 85.8 (80.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн төсвийн орлого 2026 оны эхний 4 сард 2.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 104.2 (4.6%) тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 2.2 их наяд төгрөгт хүрч,

өмнөх оны мөн үеэс 384.4 (21.1%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ. Орон нутгийн төсөв 150.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

ХҮСНЭГТ 3.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2026 оны эхний 4 сард, бүс, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	Орлого		Зарлага	
	2025 I-IV	2026* I-IV	2025 I-IV	2026* I-IV
	тэрбум төгрөг			
Дүн	2 250.3	2 354.4	1 819.2	2 203.6
Баруун бүс	135.8	120.7	114.4	137.4
Баян-Өлгий	23.5	19.4	20.3	20.7
Говь-Алтай	25.5	25.6	20.9	28.0
Завхан	27.6	25.6	24.5	28.5
Увс	27.5	27.0	23.4	27.1
Ховд	31.7	23.0	25.3	33.1
Хангайн бүс	217.3	257.5	171.9	225.5
Архангай	28.0	23.1	19.5	20.1
Баянхонгор	27.8	33.0	30.2	32.8
Булган	28.6	25.7	25.2	26.0
Орхон	68.5	116.0	41.2	82.4
Өвөрхангай	29.4	28.1	28.0	28.6
Хөвсгөл	35.1	31.7	27.7	35.6
Төвийн бүс	670.9	638.6	508.8	528.4
Говьсүмбэр	9.8	8.5	8.0	11.9
Дархан-Уул	29.2	31.9	20.1	23.4
Дорноговь	39.7	46.8	28.6	48.1
Дундговь	29.8	14.1	18.2	29.3
Өмнөговь	490.0	453.0	375.7	334.8
Сэлэнгэ	41.5	46.4	29.8	38.8
Төв	30.9	37.9	28.3	42.2
Зүүн бүс	82.4	82.9	68.1	82.3
Дорнод	25.2	29.7	19.9	28.9
Сүхбаатар	24.2	21.0	19.0	22.1
Хэнтий	32.9	32.2	29.2	31.3
Улаанбаатар	1 143.8	1 254.7	956.1	1 230.1

* Урьдчилсан гүйцэтгэл

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

Нийгмийн даатгалын сангийн нийт орлого 2026 оны эхний 4 сард 2.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 415.3 (19.7%) тэрбум төгрөг, нийт зарлага 2.2 их наяд төгрөгт хүрч, 313.9 (16.3%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

Үзүүлэлт	Жил			Эхний 4 сар			2026* I-IV 2025 I-IV	
	2023	2024	2025*	2024 I-IV	2025 I-IV	2026*I-IV	зэрүү	хувь
	тэрбум төгрөг							
Нийт орлого	4 271.6	5 609.7	6 685.4	1 818.0	2 103.3	2 518.6	415.3	19.7
Нийгмийн даатгалын орлого	3 507.3	4 434.7	5 232.9	1 258.4	1 561.9	1 873.2	311.3	19.9
Тусламжийн орлого	764.4	1 175.0	1 452.5	559.5	541.4	645.4	104.1	19.2
Нийт зарлага	4 035.0	5 104.7	5 846.8	1 558.1	1 926.2	2 240.1	313.9	16.3
Бараа үйлчилгээний зарлага ¹	42.1	0.8	0.6	0.1	0.2	0.2	0.0	-6.8
Урсгал шилжүүлэг	3 994.0	5 106.4	5 847.8	1 558.5	1 926.3	2 239.9	313.6	16.3
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	- 1.2	- 2.5	- 1.6	- 0.5	- 0.3	-	0.3	-
Тэнцэл	236.6	505.0	838.6	259.9	177.0	278.5	101.5	57.3

*Урьдчилсан гүйцэтгэл

¹ Төсвийн тухай хуулийн дагуу 2024 оноос бараа, үйлчилгээний зардал (бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжаас бусад) -ыг ГБХНХЯ-ны төсөвт шилжүүлсэн болно.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2026 оны эхний 4 сард 827.6 тэрбум төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 5.1 (0.6%) тэрбум төгрөгөөр өсөж, нийт зарлага 780.6 тэрбум төгрөг болж, 118.6 (13.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийт зардал буурахад урсгал шилжүүлгийн зардал өмнөх оны мөн үеэс 120.6 (13.4%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

Үзүүлэлт	Жил			Эхний 4 сар			2026* I-IV 2025 I-IV	
	2023	2024	2025*	2024 I-IV	2025 I-IV	2026*I-IV	зэрүү	хувь
	тэрбум төгрөг							
Нийт орлого	1 586.8	1 921.7	2 299.5	581.8	822.5	827.6	5.1	0.6
ЭМД-ын хураамжийн шимтгэл	1 586.8	1 921.7	2 299.5	581.8	822.5	827.6	5.1	0.6
Нийт зарлага	1 598.0	1 926.9	2 238.3	693.8	899.2	780.6	-118.6	-13.2
Бараа үйлчилгээний зарлага	50.0	68.3	12.7	4.7	3.0	4.7	1.7	57.6
Татаас	90.0	-	-	-	-	-	-	-
Урсгал шилжүүлэг	1 462.8	1 863.0	2 229.0	689.8	897.2	776.7	-120.6	-13.4
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	-4.8	-4.4	-3.4	-0.7	-1.0	-0.8	0.2	21.9
Тэнцэл	-11.2	-5.2	61.3	- 112.0	- 76.8	46.9	123.7	-

*Урьдчилсан гүйцэтгэл

Ойлголт, тодорхойлолт:

Монгол Улсын нэгдсэн төсөв:

Улсын төсөв, орон нутгийн төсөв, Үндэсний баялгийн сан, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого:

Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого:

Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого:

Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон

нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал:

Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого:

Тогтворжуулалтын сан, ирээдүйн өв сан, хуримтлалын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв:

Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал:

Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл:

Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.



Эх үүсвэр:

Сангийн яам

Ангилал, код:

Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилал

Мэдээлэл авах холбоос:

<https://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2026 оны 06 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын дарга М.Оюунжаргал
Утас (+976) 11-329271

Эдийн засгийн статистикийн газрын Мөнгө, санхүү, үйлчилгээний статистикийн хэлтсийн статистикч Ч.Мөнхтуул
Утас: (+976) 11-326414



/StatisticMGL



information@nso.mn



7014-1212